

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ГХЯ	Гадаад харилцааны яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.БИЛГҮҮН ТАНАА

2019.02.25 № 06/287
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн таньд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо хариуцаж хэрэгжүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн яам 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 1-4/410 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хууль зүй, дотоод хэргийн яам нь “Монгол Улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэх, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль зүйн нэгдсэн бодлогын удирдамж, хууль сахиулах стратеги, бодлого төлөвлөлтийг оновчтой тодорхойлох;
- Бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх;
- Хууль тогтоомжийн системчлэл, захиргааны байгууллагын шийдвэрийг хянах, бүртгэх, нэгдсэн сан хөтлөх;
- Хууль зүйн боловсрол, эрх зүйн сургалт, сурталчилгаа, төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүртгэл, төрөөс сүм хийдтэй харилцах;

- Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах.

Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хууль зүй, дотоод хэргийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хууль зүй, дотоод хэргийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод

хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогын 1.0 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Тайлант оны нийт орлого өмнөх оны нийт орлогын дүнгээс 93.5 хувиар өссөнтэй холбоотой юм.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны Нийт орлого 197,941.4 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 197,941.44 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь өмнөх оны болон завсрын аудитаар эрсдэл бага байсантай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	85,911.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	60,840.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	5	146,751.1	

2.8.1. Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Тайлант онд ТӨБЗГ-ын шийдвэргүй, ямар байгууллагын дансанд бүртгэлтэй байсан нь тодорхойгүй "Ниссан теана" маркийн автомашиныг ГХЯ-ны сайдаас ХЗДХС-д хүлээлгэн өгсөн ба уг Машиныг нийлүүлсэн гэх Моннис моторс ХХК-аас ирүүлсэн үнийн саналын дагуу 60,840.0 мянган төгрөгөөр үнэлэн данс бүртгэлд бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн хороонд тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", ТӨБЗГ-ын 2017 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон үл хөдлөх хөрөнгө олж авбал тухай бүр ТӨБЗГ-т мэдэгдэж, холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу бүртгэлд тусгах зөвшөөрөл авна" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Автомашиныг байгууллагын данс бүртгэлд бүртгэх тухай ТӨБЗГ-ын зөвшөөрлийг гаргуулан авч, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар буюу ХЗДХС-ын Эрхлэх асуудлын хүрээний Төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар дээр

дурьдсан автомашинтай нэгэн адил шилжүүлэн авч бүртгэсэн хөрөнгө /автомашин/ байгаа эсэхэд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хууль зүй, дотоод хэргийн яамны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 7,697.550.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тайлант хугацаанд батлагдсан дээрх урсгал үйл ажиллагааны төсөв 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан ба энэ нь Санхүү төсөв хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр төсвийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг хүргүүлэн төсвийн хуваарийг өөрчилөн зарцуулалт хийж байсантай холбоотой байна.

Үйл ажиллагааны батлагдсан нийт төсвийн 35.6 хувийг 2018 онд батлагдсан Нэг иргэн-Нэг бүртгэл үндэсний хөтөлбөрийн, бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн, мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зардлууд эзлэж байгаа ба Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 20.1 хувийг, Хууль тогтоомж боловсруулах арга хэмжээний зардал 17.2 хувийн тус тус эзлэж байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хууль зүй, дотоод хэргийн яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу ХЗДХЯ нь 2018 онд 138 мэдээллээс 128-г олон нийтэд мэдээлж 93.0 хувь, холбогдох эрх бүхий байгууллагад илгээвэл зохих 4 тайланг бүрэн илгээж 100.0 хувь, дунджаар 96.0 хувийн хэрэгжилттэй ажилласан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх онд Хууль зүй, дотоод хэргийн яамны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэх аудит хийсэн ба аудитын зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 63,575.9 мянган төгрөгийн хөрөнгийг буруу ангилж бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх", Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан Дансны зааварт "Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Байгууллагын хөрөнгө үнэгүйдэх, шамшигдах, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сулрах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд бүртгэгдсэн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, 2019 оны эхний хагас жилийн тайланд залруулга хийх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус яамны удирдлагууд аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцан, ямар нэг тайлбаргүйгээр асуудлыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан болно

3.2 Орлогын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Байгууллагын тендерийн баримт бичгийн 8,762.0 мянган төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд тусгалгүйгээр орлого бууруулан бүртгэсэн байна.

Энэ нь “Үнэн зөв байх” батламж мэдэгдэл болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэсэнтэй нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль эрх зүйн актыг мөрддөгдөхгүй байх, байгууллагын тайлант оны үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн тайлангууд буруу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны орлогыг холбогдох дансдад үнэн зөв, орхигдуулалтгүйгээр бүртгэн, тайлагнаж, орлого, зарлагыг бууруулах бичилт хийхгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус яамны удирдлагууд аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцан, ямар нэг тайлбаргүйгээр асуудлыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан болно

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Байгууллагын тендерийн баримт бичгийн орлогоос зарцуулсан 8,762.0 мянган төгрөгийн зарлагыг мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд тусгалгүйгээр орлого бууруулан бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь “Үнэн зөв байх” батламж мэдэгдэл болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэсэнтэй нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Холбогдох хууль эрх актууд зөрчигдөх, байгууллагын санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны орлого, зарлагыг холбогдох дансдад үнэн зөв, орхигдуулалтгүйгээр бүртгэн, тайлагнаж, орлого, зарлагыг бууруулах бичилт хийхгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус яамны удирдлагууд аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцан, ямар нэг тайлбаргүйгээр асуудлыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан болно.

3.4 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.4.1 Илрүүлэлт:

Нууцтай танилцах ажилтнуудад нууцын нэмэгдэл 3,704.2 мянган төгрөг, гадаад, дотоод томилолтоор ажилласан ажилтнуудад хоол, унааны мөнгө 1,107.0 мянган төгрөгийг тус тус илүү олгож, нийт 4,811.4 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журмын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Өмнөх санхүүгийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулах

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын нууц хариуцсан ажилтнаас бусад танилцах эрх бүхий албан тушаалтанд нууцын нэмэгдэл, гадаад дотоодын томилолтоор ажилласан ажилтнуудад хоол, унааны мөнгийг тус тус олгохгүй байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг тооцож, үндэсний аудитын газарт 2019 оны 6 сарын 30-ны дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	187,185,939.80	919,295,687.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	49,514,898.22	41,632,641.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	49,514,898.22	41,632,641.00
3121	Төгрөг	49,514,898.22	41,632,641.00
31211	Төрийн сангийн харилцах	49,514,898.22	41,632,641.00
33	АВЛАГА	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	15,072,828.00
34600	Урьдчилж гарсан зардал		15,072,828.00
35	БАРАА МАТЕРИАЛ	137,671,041.58	862,590,218.41
354	Хангамжийн материал	137,671,041.58	862,590,218.41
35410	Бичиг хэргийн материал	13,756,393.00	14,071,310.00
35420	Аж ахуйн материал	110,258,383.58	398,227,906.41
35430	Сэлбэг хэрэгсэл	3,674,800.00	3,674,800.00
35440	Түлш, шатах тослох материал	8,372,800.00	6,924,300.00
35460	Хүнсний материал	1,608,665.00	1,395,502.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	438,296,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	861,864,383.18	3,023,172,411.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	861,864,383.18	3,023,172,411.60
392	Биет хөрөнгө	860,176,733.30	2,339,314,791.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	876,285,060.00	1,541,335,141.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	-876,285,060.00	-5,165,724.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	669,372,685.78	789,412,685.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-393,317,555.31	-487,564,915.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	878,469,416.84	708,233,026.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-412,570,176.79	-324,712,834.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	287,484,185.03	304,094,185.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-174,505,008.79	-197,039,108.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,287,660.00	10,393,022.26
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,731,336.86	-4,357,550.28
39217	Ном	4,686,863.40	4,686,863.40
393	Биет бус хөрөнгө	1,687,649.88	683,857,620.00
39301	Програм хангамж	29,075,600.00	29,075,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-27,387,950.12	-29,075,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө		683,857,620.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,049,050,322.98	3,942,468,099.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	836,486.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	836,486.00	0.00
413	Өглөг	836,486.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	836,486.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,048,213,836.98	3,942,468,099.01

51	Засгийн газрын хувь оролцоо	1,048,213,836.98	3,942,468,099.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	535,355,550.53	535,355,550.53
51101	Өмч: - төрийн	535,355,550.53	535,355,550.53
512	Хуримтлагдсан үр дүн	431,909,483.16	1,131,596,989.12
51210	Өмнөх үеийн үр дүн	431,909,483.16	432,651,411.31
51220	Тайлант үеийн үр дүн		698,945,577.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,948,803.29	2,275,515,559.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,049,050,322.98	3,942,468,099.01

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А
/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,838,139,550.26	19,794,143,676.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	180,367,801.26	8,146,024,531.24
120	Нийтлэг татварын бус орлого	180,367,801.26	8,186,024,531.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	180,310,601.26	144,357,240.24
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	180,310,601.26	144,357,240.24
120009	Бусад орлого	57,200.00	8,041,667,291.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,657,771,749.00	11,608,119,145.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,146,576,249.00	8,520,915,772.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,146,576,249.00	7,697,550,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		823,365,572.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	511,195,500.00	3,087,203,373.38
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	244,617,969.00	656,570,004.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,481,416.00	2,420,633,369.38
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,096,115.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,708,125,643.71	18,949,271,412.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,708,125,643.71	18,638,322,890.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,452,641,107.53	9,152,412,566.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,546,285,571.00	1,503,823,654.00
210101	Үндсэн цалин	950,001,900.00	1,056,492,414.00
210102	Нэмэгдэл	284,693,900.00	294,882,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	125,666,000.00	125,666,000.00
210104	Урамшуулал	0.00	10,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	185,923,771.00	16,783,240.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,369,800.00	177,244,686.00
210201	Тэтгэврийн даатгал	105,235,300.00	122,870,286.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,033,600.00	13,593,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,026,900.00	10,874,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,006,700.00	2,718,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,067,300.00	27,187,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,215,406.00	34,808,072.00
210301	Гэрэл, цахилгаан	17,114,124.00	21,260,800.00
210302	Түлш, халаалт	1,704,111.00	10,541,572.00
210303	Цэвэр, бохир ус	2,397,171.00	3,005,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	261,321,087.23	246,753,712.40
210401	Бичиг хэрэг	49,664,802.00	37,056,683.00
210402	Тээвэр, шатахуун	32,826,004.51	27,535,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,956,419.00	39,965,500.00
210404	Ном, хэвлэл	23,704,769.00	2,680,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	93,319,541.00	125,417,031.23
210408	Бараа материал акталсны зардал	27,849,551.72	14,099,498.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,904,800.00	85,624,298.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,425,400.00	500,000.00
210604	Урсгал засвар	29,479,400.00	85,124,298.00
2107	Томилолт, зочны зардал	102,290,940.00	178,134,065.00
210701	Гадаад албан томилолт	70,876,240.00	18,820,500.00
210702	Дотоод албан томилолт	31,414,700.00	158,113,565.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,329,116,550.00	4,033,278,019.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,628,300.00	2,156,920,419.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,886,900.00	5,912,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	656,400.00	656,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,572,000.00	1,867,818,300.00
210807	Газрын төлбөр	7,357,700.00	1,970,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,232,015,250.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,991,136,953.30	2,892,746,060.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,585,759,619.37	2,339,868,510.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,059,873.45	301,776,391.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	351,317,460.48	251,101,159.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	255,525,156.18	9,485,910,323.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,959,380.00	16,349,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,349,100.00	16,349,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,810,280.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,800,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	148,525,156.18	900,899,548.22
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	37,372,647.22	

213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	9,922,653.41	858,966,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,229,855.55	41,933,548.22
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	136,161,675.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		136,161,675.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	8,432,500,000.00
213504	Хөрөнгийн		8,000,000,000.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		432,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	310,948,522.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	310,948,522.00
222001	Тоног төхөөрөмж		310,948,522.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	130,013,906.55	844,872,264.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,952,998,482.48	145,926,686.81
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,729,495,052.48	145,926,686.81
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	13,223,503,430.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-20,952,998,482.48	-145,926,686.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-20,822,984,575.93	698,945,577.81

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А
/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,657,828,949.00	19,649,786,436.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,200.00	8,041,667,291.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,200.00	8,041,667,291.00
120009	Бусад орлого	57,200.00	8,041,667,291.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,657,771,749.00	11,608,119,145.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,146,576,249.00	8,520,915,772.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,146,576,249.00	7,697,550,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		823,365,572.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	511,195,500.00	3,087,203,373.38
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	244,617,969.00	656,570,004.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,481,416.00	2,420,633,369.38
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,096,115.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,327,855,734.00	19,128,050,221.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,327,855,734.00	19,128,050,221.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,072,371,197.82	9,642,139,898.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,546,285,571.00	1,503,823,654.00
210101	Үндсэн цалин	950,001,900.00	1,056,492,414.00
210102	Нэмэгдэл	284,693,900.00	294,882,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	125,666,000.00	125,666,000.00
210104	Урамшуулал		10,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	185,923,771.00	16,783,240.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,369,800.00	177,244,686.00
210201	Тэтгэврийн даатгал	105,235,300.00	122,870,286.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,033,600.00	13,593,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,026,900.00	10,874,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,006,700.00	2,718,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,067,300.00	27,187,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,215,406.00	49,880,900.00
210301	Гэрэл, цахилгаан	17,114,124.00	21,260,800.00

210302	Түлш, халаалт	1,704,111.00	25,614,400.00
210303	Цэвэр, бохир ус	2,397,171.00	3,005,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	224,609,888.00	188,682,700.00
210401	Бичиг хэрэг	48,071,600.00	37,371,600.00
210402	Тээвэр, шатахуун	26,086,500.00	26,086,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,956,419.00	39,965,500.00
210404	Ном, хэвлэл	23,916,269.00	2,680,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,579,100.00	82,579,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,579,185.00	119,027,048.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,023,585.00	30,402,200.00
210604	Урсгал засвар	40,555,600.00	88,624,848.00
2107	Томилолт, зочны зардал	110,663,740.00	178,134,065.00
210701	Гадаад албан томилолт	70,876,240.00	18,820,500.00
210702	Дотоод албан томилолт	39,787,500.00	158,113,565.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,329,116,550.00	4,094,304,385.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,628,300.00	2,217,946,785.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,886,900.00	5,912,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	656,400.00	656,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,572,000.00	1,867,818,300.00
210807	Газрын төлбөр	7,357,700.00	1,970,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,232,015,250.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,626,531,057.82	3,331,042,460.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,572,447,184.37	3,029,266,069.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,083,873.45	301,776,391.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	255,484,536.18	9,485,910,323.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,959,380.00	16,349,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,349,100.00	16,349,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,810,280.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,800,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	148,525,156.18	900,899,548.22
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	37,372,647.22	
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	9,922,653.41	858,966,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,229,855.55	41,933,548.22
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	136,161,675.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	136,161,675.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	8,432,500,000.00

213504	Хөрөнгийн		8,000,000,000.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		432,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	329,973,215.00	521,736,214.78
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	329,973,215.00	529,618,472.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	329,973,215.00	529,618,472.00
2200	Дотоод эх үүсвэрээр	329,973,215.00	529,618,472.00
222001	Тоног төхөөрөмж		310,948,522.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	329,973,215.00	218,669,950.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-329,973,215.00	-529,618,472.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	-7,882,257.22
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49,514,898.22	49,514,898.22
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,514,898.22	41,632,641.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А
/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,355,550.53	80,948,803.29	20,654,894,059.09		21,271,198,412.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			600,000,000.00		600,000,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535,355,550.53	80,948,803.29	21,254,894,059.09	0.00	21,871,198,412.91
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			20,822,984,575.93		20,822,984,575.93
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,355,550.53	80,948,803.29	431,909,483.16	0.00	1,048,213,836.98
D01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	535,355,550.53	80,948,803.29	431,909,483.16	0.00	1,048,213,836.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			741,928.15		741,928.15
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535,355,550.53	80,948,803.29	432,651,411.31	0.00	1,048,955,765.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		2,194,566,756.07			2,194,566,756.07
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			698,945,577.81		698,945,577.81
D09	2018 оны 06-р сарын 30-нээрх үлдэгдэл	535,355,550.53	2,275,515,559.36	1,131,596,989.12	0.00	3,942,468,099.01

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		46,514,898.22	-46,514,898.22	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,697,550,200.00	7,697,550,200.00	0.00	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	7,697,550,200.00	7,697,550,200.00	0.00	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,681,201,100.00	7,681,201,100.00	0.00	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,387,754,700.00	1,387,754,700.00	0.00	100.0
Үндсэн цалин	967,206,700.00	967,206,700.00	0.00	100.0
Нэмэгдэл	294,882,000.00	294,882,000.00	0.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	125,666,000.00	125,666,000.00	0.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,530,400.00	166,530,400.00	0.00	100.0
Тэтгэврийн даатгал	112,156,000.00	112,156,000.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	13,593,600.00	13,593,600.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	10,874,900.00	10,874,900.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	2,718,700.00	2,718,700.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	27,187,200.00	27,187,200.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,880,900.00	49,880,900.00	0.00	100.0
Гэрэл, цахилгаан	21,260,800.00	21,260,800.00	0.00	100.0
Түлш, халаалт	25,614,400.00	25,614,400.00	0.00	100.0
Цэвэр, бохир ус	3,005,700.00	3,005,700.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	188,682,700.00	188,682,700.00	0.00	100.0
Бичиг хэрэг	37,371,600.00	37,371,600.00	0.00	100.0
Тээвэр, шатахуун	26,086,500.00	26,086,500.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,965,500.00	39,965,500.00	0.00	100.0
Ном, хэвлэл	2,680,000.00	2,680,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	82,579,100.00	82,579,100.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	92,757,600.00	92,757,600.00	0.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	63,807,000.00	63,807,000.00	0.00	100.0

Урсгал засвар	28,950,600.00	28,950,600.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	89,540,700.00	89,540,700.00	0.00	100.0
Гадаад албан томилолт	18,820,500.00	18,820,500.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	69,520,200.00	69,520,200.00	0.00	100.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,076,176,800.00	4,076,176,800.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,199,819,200.00	2,199,819,200.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	5,912,600.00	5,912,600.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	656,400.00	656,400.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,867,818,300.00	1,867,818,300.00	0.00	100.0
Газрын төлбөр	1,970,300.00	1,970,300.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,629,877,300.00	1,629,877,300.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,565,330,800.00	1,565,330,800.00	0.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64,546,500.00	64,546,500.00	0.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,349,100.00	16,349,100.00	0.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	16,349,100.00	16,349,100.00	0.00	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,349,100.00	16,349,100.00	0.00	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	400,000,000.00	390,865,572.00	9,134,428.00	97.7
Дотоод эх үүсвэрээр	400,000,000.00	390,865,572.00	9,134,428.00	97.7
Тоног төхөөрөмж	400,000,000.00	390,865,572.00	9,134,428.00	97.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,697,550,200.00	7,697,550,200.00	0.00	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,697,550,200.00	7,697,550,200.00	0.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	7,697,550,200.00	7,697,550,200.00	0.00	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	49,514,898.22	-49,514,898.22	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	41,632,641.00	-41,632,641.00	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	108.00	108.00	0.00	100.0
Удирдах ажилтан	10.00	10.00	0.00	100.0

Гүйцэтгэх ажилтан	90.00	90.00	0.00	100.0
Үйлчлэх ажилтан	8.00	8.00	0.00	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	108.0	108.0	0.00	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	90.00	90.00	0.00	100.0
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	5.00	5.00	0.00	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	3.00	3.00	0.00	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00	0.00	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	2.00	2.00	0.00	100.0

5 АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2018/154/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хууль зүй, дотоод хэргийн яам		Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Тайлант онд ГХЯ-ны сайдаас ХЗДХ-ийн сайдад “Ниссан теана” маркийн автомашиныг хүлээлгэн өгсөн ба уг автомашиныг ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр бүртгэж, тайлагнасан байна.	60,840.0	Төлбөрийн акт тогтоох	Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга	Г.Билгүүн, Н.Цэвэлмаа
2	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг буруу ангилж бүртгэсэн.	63,575.9	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга	Г.Билгүүн, Н.Цэвэлмаа
3	Байгууллагын тендерийн баримт бичгийн орлогыг санхүүгийн тусгалгүйгээр орлого бууруулан бүртгэж, тайлагнасан	8,762.0	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга	Г.Билгүүн, Н.Цэвэлмаа
4	Байгууллагын тендерийн баримт бичгийн орлогоос зарцуулсан зарлагыг санхүүгийн тайланд тусгалгүйгээр орлого бууруулан бүртгэсэн	8,762.0	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга	Г.Билгүүн, Н.Цэвэлмаа
5	Нууцтай танилцах албан тушаалтнуудад нууцын нэмэгдэл, гадаад, дотоод томилолтоор ажилласан ажилтнуудад хоол, унааны мөнгийг тус тус илүү олгож, нийт 4,811.4 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан	4,811.4	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга	Г.Билгүүн, Н.Цэвэлмаа
ДҮН		146,751.1			

